

Ази тивийг газарзүйн хувьд тэнгис далайн, газар тариалангийн болон нүүдлийн гэсэн гурван бүс нутагт хувааж болно. Хэдий тийм ч Азийн эх газрын түүхийг аваад үзвэл умард тал нутгийн нүүдэлчид болон «Дундад улсын» тариаланчдын хоорондын өрсөлдөөн эвлэрэл, дайн энхийн хүчинд тогтож ирсэн нь үнэнтэй.

Газар тариалангийн Хятад орон байнга байлдан ирэх аюул агуулж байсан умар зүгийн нүүдэлч улстай харьцуулахад өмнө зүгийн бага буурай улсуудын талаар тэс өөр бодлого баримталж байв. Өмнө зүгийн орнууд Хятад хүчирхэгжих үед түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, Хятад сул дорой болох үест үл тоомсорлох жишээтэй байлаа. Далай тэнгис нь Хятадын хувьд хил хязгаар бүрдүүлэх чухал агуулгатай. Хятадууд газар нутгаа «Шихай-жи нэй» буюу «Дөрвөн талаасаа тэнгисээр хүрээлэгдсэн нутаг» хэмээн нэрийдэн «хайвай» буюу «далайн чанад» дахь үйл явдлыг үл ойшоох хандлагатай. Газар тариалан эрхэлдэг хятадууд хэзээ нэгэн цагт далайн чанадаас хүчирхэг улс үндэстэн халдан ирэх боломжийг ухаардаггүй байлаа.

Нөгөө талаас, тал нутгийн нүүдэлч аймгууд их цагаан хэрмийн өмнө зүгээс үүдэж болзошгүй аюулаас үргэлж болгоомжилж иржээ. Өмнө зүгээс аюул заналхийлээгүй үед нүүдэлчид мал сүргээ адуулан, ан гөрөө хийж, тал нутагтаа амар амгалан аж төрдөг байв. Нүүдэлчдийн хувьд Монголын хойд, баруун хойд зүгт орших өргөн уудам нутаг нь «тал нутгийн тэнгис» мэт байлаа. Энэхүү онгон шахам газарт амьдрах ойн иргэд бэлчээрийн мал аж ахуй эрхлэх нүүдэлчдээс хамаарч ирсэн бөгөөд өмнө зүгийн Хятадаас аюул нөмрөх үест нүүдэлчид хойш болон баруун хойш дайжин зайлдаг жамтай. Хятадууд далайн чанадаас аюул ирэхийг ухаардаггүй байсантай адил нүүдэлчин аймгууд ч хойд болон баруун зүгээс гаднын хүчин дайрах юм чинээ санадаггүй байв.

XVIII зууны эхнээс эхлэн олон зууны түүхтэй ийм тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж ирлээ. Газар тариалангийн Хятад орны хувьд аливаа аюулын хаалт болж байсан далай тэнгис нь Өрнөдийн орнуудын худалдаачид, хар лам нарын Азид хүрэх нээлттэй дөт зам болж хувирлаа. Ингэснээр Хятадын гол анхаарал умар зүгт биш харин шинэ, улам аймшигтай гаднын аюулыг тогтоон барихын тулд далайн эрэг хавийн нутагтаа хандах болов.

Мөн нэгэн зэрэг шахам урьд нь шаардлагатай үед нүүдэлчин монголчууд эрх дураар дайжин очиж ашигладаг байсан уудам тал нутаг шинээр хүчирхэгжин гарч ирсэн хаант Оросын - мэдэлд шилжив. Төв Азийн нэг хэсэг болон Сибирь энэхүү харийн гүрний түшиц газар болж хувирснаар Азийн түүхийн зурагт засвар хийгдэв. Азийн түүхийн тавцанд шинэ хүчин гарч ирж зарим уламжлалт хуучин хүчний үүрэг хумигдав.

Байгаль цаг уурын нөхцөлөөс шалтгаалан Алтай язгуурын нүүдэлчин ард түмэн газар тариалан эрхлэх боломжгүй, тэгээд ч өөрсдийнхөө хэрэгцээг зөвхөн мал аж ахуйн бүтээгдэхүүнээр хангаж иржээ. Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүй учраас нүүдэлчид олонх тохиолдолд өмнөд хөршөөс хамааралтай байдалд байв.

*Захчид Цэцэн — монгол гаралтай, АНУ-ын Бригэм Янг Их сургуулийн профессор

Өөрсдийн хэрэгцээт зүйлсийг тайван замаар солилцон эсвэл арилжин авах бололцоогүй нөхцөлд нүүдэлчид уухайлан дайрч булаан авахад хүрдэг байв. Тиймээс ч нүүдэлчин аймгийн удирдагчид үргэлж өмнө зүгийг анхааралтай ажиглан хэзээ хүчирхэг хүч дайчлах бололцоо бүрдвэл төдийд өмнө зүгт дайлаар морддог байлаа. Хэрвээ ялагдал хүлээвэл тэд говь нутагтаа ухран буцаж алжаалаа тайлан, хүчээ нөөцлөн дахин аянд бэлтгэдэг байв. Өмнөд этгээдийн цэрэг говь нутагт нэвтэрч нэхлээ ч гэсэн нүүдэлчид хойд болон баруун хойд тийш дайжиж хүчээ нөөцлөн эргэж давших цагийг хүлээмүй.

Өмнө этгээдийн цэрэг Монголын говь нутагт хүчээр түрж орж ирж байсан удаатай. Тухайлбал, Хан улсын үеийн У-ди даан (МЭӨ 140 87) болон Хэди хаан (МЭ 89—105), түүнчлэн Мин улсын үеийн Юнлэ хаан (МЭ 1403— 1424) төр барьж байсан үед хамаарна. Тухайн үедээ хятадын цэрэг нүүдэлчдийн цэргийг бутцохин төр улсыг нь ганхуулж байсан. Гэвч Хятадууд хэзээ ч тал нутгийг байнга эзэгнэн, хатуу хянаж байсангүй. Тэд энэ нутаг, «бүдүүлэг» хүн амыг нь захирч чадахгүй байсан нь нүүдэлчдийн амьдралын онцлог, говь нутгийн байгаль цаг уурын нөхцөлтэй холбоотой. Өмнө этгээдийн цэрэг өөрсдийн хилд түрж орж ирсэн нүүдэлчдийг шахан гаргаж богино хугацаагаар амсхийх төдий л байлаа. Нүүдэлчин аймгийнхан удал ч үгүй хүчээ сэлбэн Их цагаан хэрмийн сүүдэрт ирж мал сүргээ адуулдаг байв. Ийнхүү «нуугдах-ил гарах» цэргийн арга нь умард этгээдийн нүүдэлчдийг номхруулах шилдэг арга хэзээ ч байгаагүй. Харин ч эсрэгээр хятадын цэргийн аян дайн газар тариаланч ард түмэнд өөрсдөд нь эдийн засгийн хямрал, гай гамшиг авчирдаг байв.

Умард этгээдийн нүүдэлчин ард түмэн ийнхүү урагш давшин, мөн хялбархан ухарч байсны нэгэн шалтгаан нь тэд цөм гарамгай морьтон байснаас гадна говиос хойш болон баруун хойш орших өргөн уудам нутаг чөлөөтэй байсанд оршино. Харин XVIII зууны эхнээс Орос улс дорно зүгт ноёрхлоо тэлэх болсон нь нүүдэлчдийн орон зай хумигдахад хүргэв.

XVII зууны сүүлээр Умард болон Төв Азийн нүүдэлчин ард түмнүүд өмнө этгээдийн манж Чин гүрний давуу, хүчинд түрэгдэхийн хамт нэгэн зэрэг шахуу умард этгээдээс хаант Оросын хайр найргүй даралт шахалттай учрав. Тиймээс тэд хоёр их гүрэнд хавчигдаж эрх дураар шилжих боломжоо алдав. Ийнхүү тэд хоёр их гүрний аль нэгт дагаар орохоос өөр аргагүй байдалд оров. Мөн манж Чин гүрэн болон хаант Оросын хооронд шууд харилцаа тогтоож тэд хил хязгаараа хэлэлцэн тохирсноор нүүдэлчин ард түмний чөлөөтэй шилжилт хөдөлгөөн хумигдаж, уламжлалт арга тактик нь хязгаарлагдав. Энэ нь нүүдэлчин ард түмэнд хамгийн их аюул агуулж байв. Тал нутагт гардаг ямар ч байгалийн гай гамшгаас ноцтой байлаа.

Юань гүрэн мөхсөний адраа монголчууд Монгол нутагтаа эгэн ирж Ар Юань улсыг нэг хэсэгтээ тогтоон барьсан. Дараагаар нь тэд зүүн хязгаарын монголчууд болон баруун хязгаарын ойрадууд хэмээх хоёр томоохон хэсэгт хуваагдсан. Хүчирхэг байх цагтаа тэд хоёул өмнө зүгт хөдлөн Их цагаан хэрэмд ойртон умард этгээд Орост тийм ч сэтгэл зовнихгүй байв. Нэгэн үе зүүн монголчууд Ойрадыг дийлсэн билээ. Ойрадууд заншсан ёсоор Алтайн нурууны бэлчир баруун хойд зүгт нүүдэллэн очиж хүчээ төвлөрүүлэн Зүүнгарын хаант улсыг төвхнүүлсэн юм.

Хожим нь XV зуунд Даян хаан Монголыг нэгтгэснээр Мин улсад ноцтой аюул заналхийлэх болов. Даян хаан болон түүнийг залгамжлагчид уламжлалт хэв загварыг хэлбэрэлтгүй дагав. Тэд нар өмнө эт-

гээдэд анхаарлаа төвлөрүүлэн, хааны бэлчээртээ нутаглан цэргээ Их цагаан хэрмээс нэг их холгүй байрлуулсаар иржээ. Даян хаан хүү нартаа ард иргэд, газар нутгаа хуваахдаа ч дийлэнх хэсгийг Өмнөд Монголд үлдээв. Түүний бага хөвгүүн говиос хойших Халх нутгийг өвлөн авчээ. Тиймээс даян хааны ард иргэд, хүн хүчний ихэнх говиос өмнө хэсэгт төвлөрч, умард Монгол харьцангуй сийрэг байлаа. Манж аймгууд XVII зууны эхээр сэргэн мандахын сацуу Говиос өмнө орших монгол аймгуудыг арга хүчийг хослуулан эрхшээлдээ оруулав. Халх монголчууд харьцангуй хүч буурай сул дорой байв. Тиймээс халхууд Зүүнгарт эзлэгдэх аюул тулгарахын хамт умард хөрш Оросын хаанд дагаар орох эсвэл өмнөд хөрш Манжийн эзэн хааныг түших аль нэгийг сонгоход хүрчээ. Аажмаар шашин, соёлын хэлхээ хол бооноос шалтгаалан тэд Манжийн эзэн хааны ивээлд оржээ.

Төв Азид Оросын эзлэн тэлэх бодлоготой тэмцэлдэж асан Зүүнгар Хөхнуур болон Төвдийг үндсэндээ эзэлж өнөөгийн БНМАУ-ын нутаг дэвсгэрийн бараг тал хувийг хамарч байв. Зүүнгар нь эртний нүүдлийн эзэнт гүрний хэв загварыг дагаж байсан сүүлчийн нүүдэлчдийн гүрэн байлаа. Гэвч өндийн босох үеэсээ эхлэн Зүүнгар бусад нүүдэл Чин гүрэнтэй тохиолдоогүй бэрхшээлтэй тулгарах болсон юм. Зүүнгар зүүн хойд зүгт хүчээр түрж орох хуучин бодлогыг хэрэгжүүлэх гэж оролдоод манжийн эзэнт гүрний шургуу эсэргүүцэлтэй тулгарчээ. Зүүн гарын ар талд хаант Орос их Петр хааны үед хүчирхэгжин мандах шатандаа хүрчихээд байв. Ийнхүү Зүүнгар манж болон оросуудтай аль алинтай нь тэмцэлдэхэд хүрсэн нь урьд өмнө нүүдэлчин гүрэнд тулгарч байгаагүй. Тэр ч байтугай Зүүнгар төрөлх нутагтаа ч халх чуудын эсрэг дайсагнан байлдахад хүрсэн юм.

Энэ бүх тэмцэл хэд хэдэн шийдвэрлэх байлдаанд тэдний бүх хүчийг шавхсан билээ. Тэд сүйрлээс дайжин баруун хойших нутагт дүрвэн очиж хязгааргүй тал нутагт дахин хүчээ сэргээдэг хуучин цэргийн тактикаа хэрэгжүүлэх боломжгүй болжээ. Эцсийн бүлэгт тэдний удирдагч Амарсанаа ялагдахын хамт Оросын нутагт (1757) ганцаар дутаан зайлжээ, Дагалдах нөхөдгүй болсон Амарсанаа овог аймгаа сэргээн Төв Азийн түүхийн тавцанд дахин гарч ирэх аз дутжээ. Ийнхүү Өвөр Азийн хүчний тогтолцоонд гарсан өөрчлөлт Төв Азид үнэхээрийн хүчин төгс нүүдлийн гүрэн үүсэх боломжийг үгүйсгэв.

Зүүнгарын Галдан хаан Ар Монголын Туул голын ойролцоо Зуун мод хэмээх газарт 1696 онд Манжийн хаан Кансид ялагдах үест монголын морьт цэрэг анх удаа их бууны галд өртсөн байна. Манж нар их бууг хар лам нараас зээлдэн авчээ. Энэ нь мөн нүүдэлчид орчин үеийн зэр зэвсгийн хүчинд автсан анхны түүхэнд тэмдэглэгдсэн байлдаан байлаа. Хэдийгээр монголчууд ийнхүү ялагдсанаараа орчин үеийн соёл иргэншлийн давуу талыг гарцаагүй ухаарсан боловч Сибирийн шугуй болон Чин гүрний хүрээлэлд Өвөр Азид түгжигдсэн хэвээр байлаа. Тиймээс ч тэд орчин үеийн соёл техникийн ололтоос хүртэж бусад улс үндэстний адил хөгжих бололцоогүй байв.

Эрт дээр үеэс эхлэн нүүдэлчин овог аймгуудын хоорондын дайн дажин дундаас нүүдэлчний гүрэн төрдөг жамтай. Нэг овог нөгөөгөө ялж шингээснээр хүч чадал нь төдийчинээ нэмэгддэг. Зарим үед улс төр, цэрэг болон эдийн засгийн зорилгоор овог аймгууд сайн дураар нэгдэж эвсэл байгуулдаг ч удаатай. Нүүдэлчин ард түмний давуу тал нь түргэн хөдөлж шилжих чадвартаа байдаг. Нүүдэллэх замдаа дайралдсан овог аймгуудыг дагуулан авдаг. Тиймээс нүүдэлчин овог аймгийн өсөлтийг уулын оройгоос өнхрөх цасан бөмбөлөгтэй зүйрлэж болно. Анхандаа жижигхэн бөмбөлөг аажмаар томорсоор газарт буухдаа аянга мэт хүчтэй буудаг.

Газрын тухай нүүдэлчин ард түмний ойлголт тэнгис далайн тухай далай хавийн нутгийн хүмүүсийн ойлголттой угтаа нэг. Тэд нар хүн газар хоёр салшгүй болох тухай тариаланч иргэдийн үзлийг хуваалцдаггүй. Нүүдэлч аймгийн толгойлогч ард иргэдээ дагуулан зүүнээс алс баруун тийш нүүдэллэж чадна. Тэд аль нэгэн тодорхой газарт уяг даагүй учир тариаланч хүмүүсийн санаанд багтамгүй арга тактик хэрэглэх боломжтой. Гэвч монголчуудын талаарх манжийн бодлого энэхүү давуулаг талыг үгүй хийсэн юм. Манжийн хаад «хант улсуудыг байгуулан хүчийг нь тарамдуулах» Хан улсын үеийн бодлогыг авч хэрэглэжээ. Манж нар Монгол улсыг олон тооны хошуу газарт хуваасан билээ. Тэд мөн газрын тухай хууль гарган хошуу ноён, түүний албат нарын харилцааг тодорхойлж өгснөөр Монголын феодалын системд гүнзгий өөрчлөлт хийв. Тэд Монголын ван гүн нарыг албат ардтай нь тодорхой нэгэн нутагт хадан өгч, хошуу болгоныг өөрийн бэлчээр нутагтай болгов. Хошуу ноёд, түүний албат нар хошуу нутагтаа л нүүдэллэхээс бус бусдын хошуунд нэвтрэх эрхгүй байв. Хэрвээ хэн нэг нь энэхүү журмыг зөрчих аваас зөвхөн албат бус, түүний хошуу ноён мөн адил цээрлэл хүлээнэ. Энэхүү бодлогыг хатуу баримталснаар Чин улсын хаад нүүдэлч ард түмнийг тухайлсан газар нутагт нь барьж чадсан байна. Тиймээс тал нутагт нүүдэлчин гүрэн үүсэн төрөх боломжийг үндсэнд нь хаасан байна.

Өмнөх үе цагт үймээн самуун, дайн дажны түлхээсээр нүүдэлчин овог аймгууд арга эвээр ч, хүчээр ч тэр нэгдэн цэрэг-улс төрийн хүчирхэг холбоо байгуулдаг байв. Гэтэл Чин гүрний манж хаад ураг төрөл бололцох уран аргаар Монголын ван гүн нарыг хяналтандаа авч чаджээ. Тэд Монголын ноёдыг тус тусын жижиг «хант улс»-даа сэтгэл ханамжтай байхаар нөхцөл бүрдүүлэв. Хэрвээ монголчууд манжийн эзэн хааны эсрэг ямарваа нэг үйл ажиллагаанд оролцоогүй л бол нэлээдгүй бие даасан эрх эдлэх бололцоотой байв. Нөгөө талаас эзэн хаан монголын ван гүн нарыг гаднын түрэмгийллээс хамгаалах хариуцлагыг үүрч тэднийг амар амгалан байлгах ёстой байлаа. Манж хаад Монгол ван гүн нарыг Өндөр албанд тохоож, хэргэм зэрэг хүртээн, шан харамж хайрлан өөрийн гүнж нарыг богтлон өгч ураг төрөл бололцдог байв. Монголчууд ван гүн нараа эзэн хаантай ураг болохыг ойлгосон тул манж нарын эсрэг босон тэмцэх сонирхолгүй байлаа. Ийм замаар манж нар монголчуудын дунд хямрал гарахаас сэрэмжилж, тэдний дундаас зохион байгуулах чадвартай толгойлогч төрөхийг ч хязгаарлажээ. Хэрвээ тийм толгойлогч төрвөөс нүүдлийн шинэ гүрэн байгуулах нь дамжиггүй. Гэвч манжийн бодлого монголчуудын өөрийн төр улс байгуулах бололцоог саатуулж чадсан юм.

Нүүдлийн шинэ гүрэн үүсэх боломжийг үгүйсгэхэд шашин бас багагүй нөлөөлөв. Алтан хаан Төвдөөс шарын шашныг авч XVI зууны сүүлчээр монголчуудын дунд дэлгэрүүлснээр бурхны шашны сургаал, номлол нүүдэлчин Монголчуудын зан заншил, нийгэм бусад салбарт ч ихээхэн нөлөөлөв. Шашин угийн дайчин монголчуудыг хойд насны тухай зовниход хүргэж элдэв «нүгэл» үйлдэхээс тэд тэвчих болов. Нүгэл дотроо арван хар нүгэл нь дайн дажин байлаа.

Төв Азид ийнхүү монголчууд бурхны шашинд сүсэглэж, түрэг угсааныхан Исламын шашныг шүтэх болов. Хоёр шашны хоорондын ялгаанаас болж Монгол болон түргүүд бие биенээ хардаж сэрдэх болов. Зүүнгарын эзэнт улс мөхсөнөөс хойш Төв Азийн орчинд нэгдсэн гүрэн төрөөгүйн бас нэгэн шалтгаан энэ болох нь мадаггүй. Өмнө дурдсанчлан умардын нүүдэлчин ард түмэн өмнө этгээдийн тариалангийн оронд байн байн уулгалан дайрдаг үндсэн шалтгаан нь нүүдлийн нөхцөлд үйлдвэрлэж үл чадах үр тариа, эд бараа мэтээр хэрэгцээгээ хангах

хүсэлтэй холбоотой. Хятадын төр улс хэрвээ нүүдэлчид үгүйрэн хоосрох юм бол аюулд учран сөнөж мөхнө хэмээн тооцож байв. Тэд чухамхүү ядуурал хоосрол л нүүдэлчдийг хятад нутагт уулгалан хэрэгцээт зүйлээ булааж авах замд түлхдэгийг ухаардаггүй байв. Эдгээр эдийн засгийн шалтгаанаар дайн дажин гарах үест газар тариалангийн улсууд эцэстээ нүүдэлчин ард түмэнд Их цагаан хэрмийн дагуу арилжаа наймаа хийх эсвэл тэдний шаардсан үр тариа, эд бараа зэргийг өгч салдаг байлаа. Тиймээс ч хэрвээ нүүдэлчид оршин тогтнохын тулд хэрэгцээт зүйлээ сэлбэх зайлшгүй шаардлага гарвал тэд хүчирхэг цэрэг нөөж хуралдуулан өмнө этгээдэд халддаг түүхтэй. Харин орос болон манж нар Төв болон зүүн хойд Азийг эзэлсний дараа эдийн засгийн талаар хавчих бодлогоо орхиж нүүдэлчидтэй арилжаа наймаа хийхийг хөхүүлэн дэмжих болов. Энэ бодлого нь худалдаачдад ихээхэн ашигтай, нүүдэлчин ард түмэнд ч дөхөмтэй боллоо. Тэд нар мал аж ахуйн бүтээгдэхүүнээ гэрийнхээ хаяанд л хүссэн бараагаар солих бололцоо олов. Хэдийгээр худалдаачдын залилж мэхлэх нь багагүй боловч дайн дажин хийж байснаас ийм хэлбэр нь монголчуудад ээлтэй байлаа. Ийнхүү нүүдэлчин ард түмэн амьдралын үндсэн шаардлагаар нэгдэж нягтран нэгэн зорилгын төлөө тэмцэх түүхийн хэрэгцээ нэгэнт улиран оджээ.

Англи хэлнээс орчуулсан **Ц. Батбаяр**

БНМАУ, МАНЖ-ГО УЛСЫН ХООРОНДЫН ХИЛИЙН ХЭЛЭЛЦЭЭ

Д.Гомбосүрэн*

БНМАУ, Манж-го улсын төлөөлөгчдийн хооронд 1935 оны 6-р сарын 3-наас 1941 оны 10-р сарын 15 хүртэл завсарлагаатайгаар, хэд хэдэн үе шаттай үргэлжилж, «Монгол-Манжуурын бага хурал» хэмээн түүхэнд орсон энэ хэлэлцээнд хоёр тал хэрхэн бэлтгэсэн, ямар ямар бодлого баримталсан, хэлэлцээний явц, төгсгөл, түүнийг амжилттай дуусгасан бол Алс Дорнод болон БНМАУ-ын гадаад байдалд хэрхэн нөлөөлөх байсан зэрэг олон асуудлыг судалж, хөндөж ярихгүй байсаар өнөөг хүрчээ. БНМАУ-ын 1930-аад оны гадаад бодлогын үйл ажиллагаанд томоохон байр эзлэх энэ хэлэлцээний талаар товч өгүүлье.

х х х

БНМАУ-ын Засгийн газар бүр 1931 онд Японы цэрэг Манжуурыг түрэмгийлэн эзэлсэн цагаас эхлэн, тус орны Дорнод хязгаар түгшүүртэй болж, дайн байлдааны аюул тулгарч болозшгүйг ойлгож, тухайн нөхцөл байдлыг эеэвээр шийдвэрлэхийг зорьж байлаа.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Бага Хурал, Засгийн газар, МХЗЭ-ийн Төв Хороо, Үйлдвэрчний Төв Зөвлөл зэрэг нам, төр, олон нийтийн байгууллагын идэвхтний хурал 1931 онд болж, Японы эзэрхэг түрэмгий нараас Манжуурыг цэргийн хүчээр эзэлсэн нь ЗСБНХУ, БНМАУ-ын дорнод хязгаарыг түгшүүртэй болгож байгааг онцлон тэмдэглээд: «...Манжуурт байсан хэргийг сайтар ширтэн харж, тус орныг

* Цэргийн түүхийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, дэд эрдэмтэн, хурандаа.